САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 8 сарын 28 өдөр Дугаар 242 Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллагуудыг
нэгтгэж, тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Компанийн тух ай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.5, Хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 7.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Итгэлбизнес ББСБ" ХХК-ийг "Аргумент ББСБ" ХХК-тай нэгтгэхийг зөвшөөрсүгэй.

2. "Итгэлбизнес ББСБ" ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Аргумент ББСБ" ХХК /Ц.Алтанчимэг/-д үүрэг болгосугай.

4. "Итгэлбизнес ББСБ" ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА С.ДАВААСҮРЭН

E:\ajil 2019\Blank\Togtool.doc